

“ ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26

№ 24/04

Дархан Уул аймаг


Компанийн тухай хуулийн 80.4, 87, 88 дахь заалтууд “Дархан зочид буудал” ХК-ийн 2024 оны 09 сарын 26-ны өдөр явуулсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. Компани өөрийн хөрөнгөө болох / “Дархан зочид буудал” ХК-ийн “Дархан Уул аймгийн Дархан сумын 11-р багт байршилтай 8072 м.кв талбайтай, Ү-2003006754 дугаартай Зочид буудал, рестораны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, 17.000 м.кв талбайтай, НТД:080100141 дугаартай үйлчилгээ зочид буудлын зориулалттай эзэмших эрхийн газрыг барьцаалж / “Худалдаа хөгжлийн банк”-наас 1.500.000.000 / нэг тэрбум, таван зуун сая / төгрөгийн зээлийг 5 /тав / жилийн хугацаатай, 1.4 %-ийн хүүтэйгээр зээл авах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирал Э.Алтанзул-д зөвшөөрсүгэй.
2. Зээл, барьцааны гэрээнд гарын үсэг зурах, барьцаанд бүртгүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал Э.Алтанзул-д олгосугай.
3. Уг зээлийг авахаар хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнийн дүнтэй зээл байгаа тул **ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ**-д тооцсугай.
4. Дээрх зээлийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга П.Алимаа-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГИШҮҮД



П.АЛИМАА

Н.МӨНХДАШ

В.МЯГМАРДАШ

Д.ДАЯНБИЛГҮҮН

Н.ПҮРЭВДАШ

Э.АЛТАНЗУЛ

Б.БАЯРБАТ

Л.АРИУНТУЯА

Э.МЯНГАНБАЯР